



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Г.ЛУВСАНЖАМЦ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.08.18 № 12198
танай _____-ны № _____-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж агаарын бохирдлыг бууруулах төсөл, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл бэлтгэж ирүүлэх тухай Таны асуултын хариуг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 10 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255013184

Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж агаарын бохирдлыг бууруулах
төсөл, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл бэлтгэж ирүүлэх тухай
Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын
асуултын хариу

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрт тусгагдсан 17 арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд, орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг бүх шатны Засаг дарга Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран гүйцэтгэх, Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Сангийн сайд, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосон.

Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоол, 2020 оны 115, 211 дүгээр тогтоолоор агаарын чанарын бүсэд гэр хорооллын айл өрхөд шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны үнийн хөнгөлөлтийг олгох эрхзүйн орчныг бүрдүүлж санхүүжилтийг олгосон.

Мөн Засгийн газрын 2018 оны Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай 62, 2020 оны 189, 2022 оны 223 дугаар тогтоолоор Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Налайх дүүргийн бүх хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон.

Улсын Их Хурлын 2018 оны 2 дугаар тогтоолын 4 дэх заалт, “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” Засгийн Газрын 2018 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх чиг үүрэг бүхий “Тавантолгой түлш” ХХК-ийг байгуулж, “Энержи ресурс” ХХК-ийн Ухаа худгийн угаасан нүүрсний үйлдвэрээс гарч байгаа завсрын бүтээгдэхүүн болох мидлингийг боловсруулж шахмал түлш үйлдвэрлэх ажлыг эхлүүлсэн. Мөн 2020 оны 35 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын зүүн бүсэд сайжруулсан шахмал түлшний үйлдвэр тус тус барьж ашиглалтад оруулах тухай шийдвэр гарсан.

2017 онд Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр батлагдаж Ерөнхий сайд /Ж.Эрдэнэбат/-ын 2017 оны 51 дүгээр захирамжаар дээрх хороог “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо” болгон өөрчилж Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар шийдвэрлэж даргаар Байгаль орчин аялал жуулчлалын сайд

Н.Цэрэнбатыг томилсон бөгөөд 2022 он хүртэл байгаль орчин аялал жуулчлалын сайдуудын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч агаарын бохирдлыг бууруулах төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгож байсан.

Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолоор Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороог Эрчим хүчний сайд Б. Чойжилсүрэнгийн эрхлэх асуудлын хүрээнд, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 396 дугаар тогтоолоор Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороог татан буулгаж чиг үүрэг, үйл ажиллагааг Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатарын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэн.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог шинээр байгуулж даргаар Байгаль орчин, уур амьсгалын сайд, дэд даргаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарыг томилсон.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцад харьяалах “Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөр”-ийн зардлаас 2020-2024 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр нийт 243,3 тэрбум төгрөгийг зарцуулахаар баталснаас 275.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүний 189,8 тэрбум төгрөгийг агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2025 онд Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардал 9,5 тэрбум төгрөгийг төсөвлөсөн боловч төсвийн тодотголоор 5.1 тэрбум төгрөг болж буурсан. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зардлаас албан бичигт дурьдсан төсөл арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ажилласан байна.

1. Улсын хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2020 оноос хойш хэрэгжүүлсэн болон одоо хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ, бодлогын хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл

1.1 Түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, орлуулах түлшний татаас олгох хөтөлбөрийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлээр “Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах тухай” үүргийн дагуу 2019 оны 9 дүгээр сард Сонгинохайрхан дүүргийн Толгойт өртөөнд, мөн Засгийн газрын 2020 оны 35 дугаар тогтоолын дагуу 2020 оны 12 дугаар сард Төв аймгийн Сэргэлэн суманд сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг тус тус барьж ашиглалтад оруулсан. Үйлдвэр ашиглалтад орсноор 2019-2024 онд 2.7 сая тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэн Улаанбаатар хотын 7 дүүргийн 199.8 мянган хэрэглэгчдэд нийлүүлсэн байна. Энэхүү арга хэмжээ хэрэгжихээс өмнө 2018 оны судалгаагаар 200.0 мянган өрхийн түүхий нүүрсний хэрэглээ 990.0 мянган тонн байсан ба сайжруулсан шахмал түлшний 2019-2024 онд үйлдвэрлэж, нийлүүлсэнтэй харьцуулбал дундажаар 48.8 хувиар түүхий нүүрсний хэрэглээг бууруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Нийслэлийн төвийн зургаан дүүргийн агаарын чанарыг сайжруулах бүсийн 200 мянган орчим иргэнийг сайжруулсан шахмал түлшийг хот доторх тээвэрлэлт, үнийн дүнгийн зөрүүний татаас болон Зүүн бүсийн үйлдвэрийг шинээр барих үйл ажиллагаанд “Таван толгой түлш” ХХК-нд 53,8 тэрбум төгрөг, Сайжруулсан хатуу түлшний хадгалалт, агуулах, боруулалтын цэгийн түгээлтэд зориулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 8,5 тэрбум, Дархан-Уул, Өвөрхангай аймагт түлшний үйлдвэрийг барих зэрэг үйл ажиллагаанд нийт 4.3 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Мөн Засгийн газрын 2019 оны “Агаарын бохирдлын эсрэг авах зарим арга хэмжээний тухай” 158 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Экологийн цагдаагийн албанд Эргүүл, хяналт шалгалтын 58 хүний орон тоотой нэгжийг байгуулж Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт Монгол улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хяналт шалгалтын 30 ажилтан, нийслэл хотруу орж ирэх гол замуудад 4 хяналтын явуулын постыг шинээр байгуулан шалган нэвтрүүлэх 7 цэгт түүхий нүүрсийг агаарын чанарыг сайжруулах бүсэд нэвтрүүлэхийг хориглох арга хэмжээний санхүүжилт болон Тавантолгой түлш ХХК-ийн шахмал түлш үйлдвэрлэх үйл ажиллагаанд 24 цагийн хяналт тавих НМХГ-ын 450 албан хаагч, Агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс түлж байгаа эсэхэд хяналт тавих 4600 хүнээс бүрдсэн хяналтын баг, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт хяналт шалгалтын багаж тоног төхөөрөмж, явуулын лаборатори автомашин, Экологийн цагдаагийн газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт алслагдсан дүүрэгт хяналт шалгалт хийхэд зориулан автомашин худалдан авах зэрэг үйл ажиллагааны зардалд 2019-2022 онд нийт 11,9 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Засгийн газрын 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн агаарын чанарын бүсэд “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшийг хэрэглэхтэй холбоотойгоор угаарын хийн эрсдэлээс сэргийлэх автомат систем ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, угаарын хийн хордлогын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, агаарын бохирдлын мэдээллийн сан үүсгэх, хэвлэл мэдээлэл, шторк, гарын авлага, эрдэм шинжилгээний хурал, агаарын чанарын бүсэд орсон иргэдэд хийх уулзалт зэрэг нөлөөллийн ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд нийт 8,9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Түүхий нүүрсний хэрэглээ, сайжруулсан шахмал түлшний татаасын мэдээлэл

д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Он						
			2019	2020	2021	2022	2023	2024	2025 II
1	Сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлт	мян.тонн	165,723	446,344	557,734	500,265	518,800	511,800	-

2	Сайжруулсан шахмал түлш авсан өрх		өрхийн тоо	160,000	187,000	199,860	193,880	190,164	191,175	-
3	Сайжруулсан шахмал түлшний өртөг		мян.төг/тн	425.5	358.6	390.5	517.8	572.8	598.9	-
4	Санхүүжилтийн хэмжээ		тэрбум.төг	128.2	170	218	359.2	265.4	281	42
4.1	Санхүүжилтийн эх үүсвэр	"ЭТТ" ХК-ийн санхүүжилт	тэрбум.төг	111.8	138.7	180.8	352.2	265.4	281	42
		Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраас		2.4	5.8	9.1	6.9	0	0	0
		Байгал орчин аялал жуулчлалын яамны дэмжлэг		14.1	25.5	28.1	0.1	0	0	0
5	Санхүүжилтийн зарцуулалт		тэрбум.төг	128.2	170	218	359.2	265.4	281	42
5.1	Хөрөнгө оруулалт			39.5	68.2	33.1	114.5	48.8	60	8
5.2	Үндсэн үйл ажиллагаанд			88.7	101.8	184.9	244.7	216.7	221	34

1.2 Айл өрх болон нийтийн орон сууцны дулаалгыг дэмжих төсөл, арга хэмжээний талаар

Европын холбооны Nama Facility байгууллагын 18.0 сая евро болон Барилга хот байгуулалтын яам (хуучин нэрээр)-ны 8.0 сая евро, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 6.5 сая евроны санхүүжилтээр Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (GIZ)-ын хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл 2022 оноос Улаанбаатар хотын угсармал хийцтэй 375 блокийг дулаалах зорилгоор хэрэгжиж эхэлсэн.

1.3 Эрчим хүчний хэмнэлт бий болгох болон сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхтэй холбоотой төсөл хөтөлбөрүүдийн талаар

Засгийн газрын 2017 оны 199-р тогтоолын хавсралтаар баталсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-д Аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын өрхийн ахуйн хэрэглээ болон халаалтын зориулалтаар хүйтний улиралд орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг 50 хувиар бууруулж хөнгөлөлт үзүүлэхээр заасныг ЗГ-ын 2020 оны 115-р тогтоолд 100 хувь болгон өөрчлөлт оруулснаар цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг зөвхөн УБ хотод бус 21 аймгийн төв, 10 мянгаас дээш хүн амтай 3 суманд үзүүлэхээр Эрчим хүчний сайдын багцаас санхүүжүүлсэн бөгөөд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос дээрх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болон байгальд ээлтэй ногоон төсөл, үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн хүүгийн татаас олгох, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, гэр, байшингийн дулаалга, зэрэг 26 нэр төрлийн “ногоон” бүтээгдэхүүнийг худалдан авахад зориулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагад ногоон зээлийн үйлчилгээг Хас, Хаан, Төрийн банкт хамтран хэрэгжүүлэх ажилд нийт 11,72 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Эрчим хүч хэмнэлтийн хууль 2015 онд батлагдсан бөгөөд тус хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээний босго

хэмжээг Засгийн газрын 2019 оны 182 дугаар тогтоолоор баталж 163 хэрэглэгч, 2023 оны 67 дугаар тогтоолоор шинэчлэн баталж 330 хэрэглэгчид үүрэг хүлээлгэн, 2018-2024 онд 5571 ажилд 272.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 283.2 сая кВтц цахилгаан эрчим хүч, 233.7 мянган Гкал дулааны эрчим хүчний хэмнэлт хийсэн болно.

Эрчим хүч хэмнэлтээр бууруулсан хүлэмжийн хийн хэмжээ

Он	ҮХХ-ийн тоо	Хэрэгжүүлсэн ажлын тоо	Зарцуулсан хөрөнгө оруулалт сая төг	ЭХХэмнэлт		СО ₂ ялгарлын бууралт
				сая.кВт.ц (мян.Гкал)	сая төг	мян.тонн
2018	82	-	-	51.7	8,500.0	38.8
2019	129	866	-	68.5 (44.6)	4,917.7	69.5
2020	211	925	41,657.7	69.5 (1.4)	11,984.0	78.1
2021	197	1075	44,582.3	38.4 (28.2)	27,797.8	67.6
2022	197	947	39,530.4	18.7 (41.3)	10,829.0	31.0
2023	279	768	61,011.7	16.9 (60.8)	4,422.9	37.3
2024	226	990	85,761.0	19.5 (57.4)	5,365.6	38.0
Өссөн дүнгээр		5571	272,543.1	283.2 (233.7)	73,817.0	360.3

Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк (АХБ) хооронд гэрээний дагуу Монгол Улсын баруун аймгуудад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр байгуулах, эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Азийн хөгжлийн банкны зээл, Стратегийн цаг уурын сан (буцалтгүй тусламж), Японы Хамтарсан кредитын сан (буцалтгүй тусламж)-ийн хөрөнгөөр тус төслийн хүрээнд нийт 45.1 МВт хүчин чадалтай 5 нарны цахилгаан станцыг барьж Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний системд холбох ба мөн эрчим хүчний системд цэнэг хураагуурын тархмал системүүдийг суурилуулахаар ажиллаж байна. Үүнд:

1. Ховд аймгийн Мянгад суманд 4 МВт/8 МВт.ц багтаамжтай 19.8 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын төслийн бэлтгэл ажлыг хангаж, Азийн хөгжлийн банкнаас зөвшөөрлийг авч тендерийг 2025.05.30-нд зарласан. Тендерийн материалыг 2025.08.13-ны өдрийн 14 цагт хүлээн авч, үнэлгээ хийгдэж байна.

2. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 10 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100% хийгдэж, эрчим хүчний системд холбогдсон. Үйлдвэрлэсэн ЦЭХ: 33,856,670 кВт.цаг/жил

3. Говь-Алтай аймгийн Алтай сумын 600кВт/3000кВт.ц багтаамж бүхий 300 кВ-ын нарны цахилгаан станцын хосолмол системийн түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100% хийгдсэн. Үйлдвэрлэсэн ЦЭХ: 2,085,624 кВт.цаг/жил.

4. Завхан аймгийн Улиастай сумын 5 МВт нарны цахилгаан станцын түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100%

хийгдсэн ба ашиглалтад орсноос хойш Борх 25,209,571.8 кВт.цаг/жил, Цэнгэг 2,482,460.8 кВт.цаг/жил ЦЭХ-ийг үйлдвэрлээд байна.

5. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 МВт нарны станцын түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 98.0%-тай, эрчим хүчний системд холбогдсон. Үйлдвэрлэсэн ЦЭХ: 16,756,750 кВт.цаг/жил байна.

Баруун бүсэд 3 үе шаттай хөрсний дулааны насосын 500кВт чадалтай технологийг нэвтрүүлж нийтдээ 10000 м.кв талбайг дулаанаар хангах ажлыг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгын дулаан хангамжид 135 кВт хүчин чадал бүхий "Гүний дулааны халаалтын систем"-ийн угсралт суурилуулалтын ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100% хийгдсэн.

2. Завхан аймгийн Улиастай сумын Жаргалант цогцолбор сургуулийн барилгад хөрсний дулааны насосын системийг суурилуулах ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100% гүйцэтгэгдсэн.

3. Говь-Алтай аймгийн Алтай сумын эмнэлэг, захиргааны барилгад хөрсний дулааны насосын системийг суурилуулах ажлын гүйцэтгэл 35%-тай байна.

4. Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар сургуулийн барилгад хөрсний дулааны насосын системийг суурилуулах ажлын гүйцэтгэл 50%-тай байна.

5. Баянхонгор аймгийн Өлзийт сумын сургуулийн барилгад хөрсний дулааны насосын системийг суурилуулах ажлын гүйцэтгэл 48%-тай байна.

1.4 Айл өрхүүдэд халаалтаа цахилгааны эх үүсвэр, сэргээгдэх эрчим хүчээр шийдэх боломжийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн дэд станц, дамжуулах шугамыг сайжруулах, өргөтгөх төсөл арга хэмжээний талаар

Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 199 тогтоолоор "Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг баталсан бөгөөд 2020 оны 115, 2025 оны 115 дугаар тогтоолуудаар тус журмыг шинэчлэн баталсан.

Гэр хорооллын айл өрхүүдийг халаалтаа цахилгааны эх үүсвэрээр шийдэх боломжийг бүрдүүлэх хүрээнд цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтөд 2017-2024 онуудад гүйцэтгэлээр нийтдээ 156,411.5 сая төгрөг санхүүжүүлсэн бол 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 81,812.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор байна.

Эрчим хүчээ сэргээгдэх эрчим хүчээр шийдэх боломжийг бүрдүүлэх хүрээнд Эрчим хүчний сайдын 2020 оны 159 дугаартай "Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журам" батлагдсан ба Эрчим хүчний зохицуулах хорооноос сүлжээнд нийлүүлэх тарифыг дараах байдалтай баталсан болно. Үүнд:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф (2021.06)	Шинэчилсэн тариф (2025.02)
1.	Өдрийн цагаар /06:00 - 17:00 цаг/	Төг/кВт.ц	140.18	285
2.	Оргил ачааллын үед буюу оройн цагаар /17:00 - 22:00 цаг/	Төг/кВт.ц	221.89	300

Энэхүү арга хэмжээний үр дүнд өнөөгийн байдлаар улсын хэмжээнд 81 хэрэглэгч нийт 1,484 кВт-ын нарны үүсгүүр болон 506 кВт.цаг багтаамжтай батерэй хуримтлуурыг түгээх сүлжээнд холбосон байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрийн 4.1.8-д “Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг хэсэгчилсэн инженерийн хангамжид холбох, дэд төвүүдийг байгуулах, сэргээгдэх эрчим хүчний технологи нэвтрүүлэх зорилтын хүрээнд нийслэлийн агаарын чанарын бүсэд байгаа 126 ААН-ийн 220 зуух, Төсвийн байгууллагын 17 объектыг төвлөрсөн дулаанд холбох, 10 цэцэрлэг, 2 сургуулийг хийн халаагуурт холбох, 11 сургууль цэцэрлэгийг цахилгаан халаагуурт холбох 1 сургуулийг газрын гүний дулаанаар хангах, агаарын чанарын бүсэд 4 квт-ийн чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломж бүрдүүлж 10028 айл өрхийг хамруулах 12 багц ажил, сургууль цэцэрлэгийн дотоод орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд зориулж цонхны шүүлтүүр тавих, Нийслэлд агаарын бохирдлыг тасралтгүй хэмжих 1 суурин харуул шинээр байгуулах PM10/PM2.5 тоосонцор хэмжих 15 ширхэг багаж, тоног төхөөрөмжийг худалдан авах зэрэг төсөл арга хэмжээнд 32,3 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

- Орон нутагт 4 аймгийн ДЦС-ын шүүлтүүрийг солих, 3 аймгийн ДС-д шүүлтүүр сурилуулах, 30 халаалтын зуух болон нам даралтын зууханд утаа шүүгч шүүлтүүр сурилуулах, 2 аймгийн дулааны магистрал шугамыг солих, аймгуудын агаарын бохирдлыг хянах харуулын байр суурилуулж, 5 аймгийн цаг уур, орчны шинжилгээний төвүүдэд PM2.5 тоосонцор хэмжих багаж худалдан авах зэрэг төсөл арга хэмжээнд нийт 8,7 тэрбум төгрөгийг зарцуулсан.

Мөн эрчим хүчний салбарт 2020 оноос хойш агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсаргав.

2. Дээрх төсөл арга хэмжээ бүрийн жил бүрийн төсөв, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтын талаарх мэдээлэл

Түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, орлуулах сайжруулсан шахмал түлшний татаасын мэдээллийг хүснэгтээр харуулав.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын санхүүжилтийн мэдээллийг хүснэгтээр харуулав.

Эрчим хүч хэмнэлтээр бууруулсан хүлэмжийн хийн хэмжээ

Он	ҮХХ-ийн тоо	Хэрэгжүүлсэн ажлын тоо	Зарцуулсан хөрөнгө оруулалт сая төг	ЭХХэмнэлт		CO ₂ ялгарлын бууралт
				сая.кВт.ц (мян.Гкал)	сая төг	мян.тонн
2018	82	-	-	51.7	8,500.0	38.8
2019	129	866	-	68.5 (44.6)	4,917.7	69.5
2020	211	925	41,657.7	69.5 (1.4)	11,984.0	78.1
2021	197	1075	44,582.3	38.4 (28.2)	27,797.8	67.6
2022	197	947	39,530.4	18.7 (41.3)	10,829.0	31.0
2023	279	768	61,011.7	16.9 (60.8)	4,422.9	37.3

2024	226	990	85,761.0	19.5 (57.4)	5,365.6	38.0
Өссөн дүнгээр		5571	272,543.1	283.2 (233.7)	73,817.0	360.3

**Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2019-2025 оны санхүүжилт,
зарцуулалтын мэдээ**

№	Зардлын зүйл	Төсөвт өртөг /мян. ам.доллар/	Эх үүсвэр /мян.ам.доллар/			Зарцуулалт							Нийт зарцуулалт
			АХБ Зээлийн хөрөнгөнөөс	Уур амьсгалын сангийн буцалтгүй тусламж	Япон Улсын ХЗС-ын буцалтгүй тусламж	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	
1	Мянгадын нарны станц	19,710.00	11,940.00	7,770.00		-	-	-	-	-	-	-	-
2	Алтай хотын нарны станц	10,442.25	4,612.25	5,830.00		-	-	-	20,817.90	7,846.92	2,695.43	173.89	31,534.15
3	Алтай сумын хосломол систем	1,078.94	1,078.94	-		-	-	248.15	2,678.77	62.01	386.41		3,375.34
4	Улиастай хотын нарны станц	7,353.69	2,448.60	-	4,905.09	-	-	9,659.98	8,373.83	1,988.81	-		20,022.62
5	Мөрөн хотын нарны станц	9,498.87	9,498.87			-	-	-	2,992.28	-	22,536.70		25,528.98
6	Газрын гүний дулааны халаалт-Ховд	261.10		261.10		-	-	624.61	48.34	-	-		672.95
7	Газрын гүний дулааны халаалт-Улиастай	189.53		189.53		-	-	-	494.70	-	-		494.70
8	Газрын гүний дулааны халаалт-Баянхонгор	293.28		293.28		-	-	-	-	-	437.91		437.91
9	Газрын гүний дулааны халаалт-Улаангом	331.00		331.00		-	-	-	-	-	638.11		638.11
10	Газрын гүний дулааны халаалт-Алтай	248.89		248.89		-	-	-	-	74.24	156.96		231.20
11	Тэлмэнгийн хуурмаг чадал компенсалах төхөөрөмж суурилуулах	1,145.85	1,145.85			-	-	-	271.79	3,308.29	359.17		3,939.25
12	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	104.29	104.29			-	-	-	290.55	64.62	-		355.16
13	Салхины төхөөрөмж зөөвөрлөх, суурилуулах	50.20	50.20			-	-	-	170.66	-	-		170.66
14	Сургалт хийх	18.00	18.00							24.94	36.56		61.49
15	Хяналт хийх	92.01	92.01								176.81	59.28	236.08
16	ТХ-д зөвлөх үйлчилгээ	1,682.10	682.10		1,000.00	273.33	1,138.38	776.21	743.51	-	935.50		3,866.93
17	Мянгадын нарны станцын ТЗЗҮ	44.62	44.62								119.09	113.37	232.47
18	Мянгадын нарны станцын байгаль орчны үнэлгээ	41.72	41.72								72.65	120.52	193.17
19	JCM MRV expert	117.41	117.41										-
20	ТХ	1,280.00	1,280.00			510.86	683.01	694.99	685.52	753.82	681.39	526.84	4,536.44
	НИЙТ ДҮН	53,983.74	33,154.85	14,923.80	5,905.09	784.19	1,821.38	12,003.94	37,567.84	14,123.64	29,232.69	993.91	96,527.58

Айл өрхүүдийн халаалтаа цахилгааны эх үүсвэрээр шийдэх боломжийг бүрдүүлэх зорилгоор цахилгааны тарифын хөнгөлөлт гэр хорооллын айл өрхийн хэрэглэгчдийн 2017-2026 оны орой, шөнө, өглөөний цагт хэрэглэсэн цахилгааны тарифын хөнгөлөлт

Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 ХБГ	2026 төлөв
1 Хэрэглэгч тоо	119,413	122,988	138,552	151,277	156,027	169,662	182,145	202,201	243,440.0	265,418.0
2 ЦЭХ-ний хэрэглээ, мян.кВт.ц	73,547.5	116,826.3	142,623.8	170,027.2	217,601.6	231,044.2	240,736.9	285,063.1	440,401.2	536,457.5
3 Хөнгөлөлт, сая төг	6,326.9	9,843.5	12,955.4	18,088.6	23,581.8	25,337.1	26,340.5	33,937.7	81,812.7	104,244.0

Төв, Зүүн, Өмнөд, Баруун, Алтай-Улиастай эрчим хүчний системийн цахилгаанаар хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч 16 компаниас агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн төв болон арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын цагийн ялгаварт тарифт тоолууртай 265.4 мянган цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн 1, 2, 3, 11, 12 дугаар саруудын оройн 21:00 цагаас өглөөний 09:00 цагийн хооронд хэрэглэсэн цахилгааны тарифт 2026 онд хөнгөлөлт үзүүлэхэд шаардлагатай 104,244.0 сая төгрөгийг Эрчим хүчний сайдын багцын 2026 оны төсвийн төсөлд тусган холбогдох газруудад хүргүүлээд байна.

Мөн эрчим хүчний салбарт 2020 оноос хойш агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсаргав.

3. Хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хяналт үнэлгээ, аудитын газрын хяналт шинжилгээ үнэлгээний дүгнэлтээр 2023 онд 17 арга хэмжээний гүйцэтгэл 50.0%, 2024 онд 9 арга хэмжээний гүйцэтгэл 51.5%, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 9 арга хэмжээний гүйцэтгэл 54.6%-тай үнэлэгдсэн байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт 51.38 хувьтай буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлж дараах зөвлөмжийг ирүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны Аудитын сэдэв батлах тухай 2024 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн “Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2021-2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийхээр урьдчилсан судалгааны ажлыг эхлүүлсэн бөгөөд 28 ширхэг 141мб хэмжээтэй анхан шатны баримт бичгийн бүрдүүлбэрийг хүргүүлэн хамтарч ажиллаж байна.

4. 2026 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болон шинээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээ, хөтөлбөр, түүнд шаардагдах төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл

4.1. Хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд

- Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах ;

- Ногоон зээл олгох эх үүсвэрийг шийдвэрлэх;

- Агаарын чанарыг сайжруулах бохирдлыг бууруулах стандартуудыг шинэчлэн боловсруулж, батлуулах. (хатуу түлш, барьцалдуулагч, агаарын чанар, дулаалга)

4.2. Хатуу түлшний хэрэглээг бууруулах ажлын хүрээнд

- Гэр хорооллын айл өрхийн дулаан алдагдлыг бууруулах, уурын болон усан халаалтын нам даралтын зуухуудад технологийн шинэчлэлт хийхэд санхүүгийн эх үүсвэрийг ААНОАТТХ-ийн татварын 1 хувийг хөнгөлөх замаар санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

4.3. Сайжруулсан шахмал түлшний технологийн шинэчлэлт хийх ажил

- Дунд хугацаанд агаарын чанарт нөлөө үзүүлэхгүй олон улсын худалдааны шаардлага хангасан экологийн цэвэр түлшийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

4.4 Орон нутагт агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд:

- Дулааны станц ашиглалтад орсон аймгуудын агаарын чанарын бүсэд орсон зуухнуудыг төвлөрсөн шугамд холбуулах, цахилгаан станцгүй аймгуудын зууханд стандартын шаардлага хангасан шүүлтүүр тавиулах, зууханд технологийн шинэчлэл хийх

- Аймгуудын төвийн түүхий нүүрсний хэрэглээг үе шаттай багасгаж, стандартын шаардлага хангасан шахмал түлш болон хийн болон сэргээгдэх эрчим хүчинд шилжүүлэх

4.5 Эрчим хүчний салбарт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудаас 2025 онд шилжин хэрэгжих 25 төсөл, арга хэмжээнд 274,2 тэрбум төгрөг, 2026 онд шинээр эхлүүлэхээр 5,476.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг УИХ-ын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга, эрчим хүчний салбарын үйлдвэр компаниуд болон бусад байгууллагуудаас ирүүлснээс зайлшгүй шаардлагатай зураг төсөв хийгдсэн хөрөнгө оруулалтыг эрэмбэлэн шинээр эхлүүлэхээр 3,917.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 93 төсөл, арга хэмжээний 2026 оны санхүүжилтэд 1,699.5 тэрбум төгрөг нийт 118 төсөл арга хэмжээний 3909,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2026 онд санхүүжих дүн нь 1973,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрчим хүчний сайдын 2026 оны төсвийн төсөлд тусган хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлээд байна.

---o0o---